



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Утас: 88094175

Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.24 № 1/124
танай 2024.03.01 № 1/84 -Т

АЛТАЙ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Х.ТҮМЭНДЭЛГЭР ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

ОНХС-ийн төсөл арга хэмжээг батлахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь: ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.4 "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5 Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно, 29.1 Захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ", Төсвийн тухай хууль, Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төв, зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Татварын болон татварын бус орлогыг нийт 430,357.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 107,313.0 мянган төгрөг буюу 33.2 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 42,659.3 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 4,414.8, газрын дуудлага худалдаанаас 9,025.0 мянга, ус рашааны нөөц ашигласны төлбөр 1,071.8 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 407.0 мянга, хүү торгуулийн орлого 9,435.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Харин газрын төлбөр 2,349.3 мянган, улсын тэмдэгтийн хураамж 4,902.3 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3,514.7 мянга, байгалийн ургамал ашигласны төлбөр 8,190.0 мянга, төгрөгөөр тус тус тасалжээ.

Аудитын гол асуудал

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж 89,460.5 мянга, машин тоног төхөөрөмж 100,369.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 37,565.0 мянган төгрөг, зам гүүрийн байгууламж 128,077.9 мянган төгрөг нийт 355,473.3 мянган төгрөгөөр нийт үндсэн хөрөнгө нэмэгдэж Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/08 дугаар тогтоолоор Алтай сумын сургуулийн данс бүртгэлд бүртгэлтэй 23,500.0 мянган төгрөгийн үнэтэй элэгдлийн зардлаа нөхсөн УАЗ 3151622/Пургон авто машиныг ЗДТГ-ын данс бүртгэлд шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 03 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 91.6 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,194,183.60	1,428,511.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	471,714.20	538,242.10
33	АВЛАГА	248,497.10	282,243.20
34	УРЬДЧИЛГАА	223,298.30	461,488.10
35	БАРАА МАТЕРИАЛ	250,674.00	146,538.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,861,859.60	4,014,382.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,861,859.60	4,014,382.00
39200	Биет хөрөнгө	3,857,390.90	4,010,022.60
39300	Биет бус хөрөнгө	4,468.80	4,359.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,056,043.30	5,442,893.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,246.10	818.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,246.10	818.9
41300	Өглөг	28,246.10	818.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,027,797.20	5,442,074.50
51	Засгийн газрын хувь оролцоо	5,027,797.20	5,442,074.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,034,383.70	1,034,383.70
51200	Хуримтлагдсан үр дүн	3,414,991.20	3,829,268.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	578,422.40	578,422.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН Д ҮН VI=IV+V	5,056,043.30	5,442,893.40

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,025,550.40	2,835,089.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	427,667.80	419,924.50
110	Орлогын албан татвар	218,932.40	302,812.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	218,932.40	321,305.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-18,492.80
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0	0
113	Хөрөнгийн албан татвар	34,216.50	32,799.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	174,518.90	84,312.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	854,778.80	409,171.40

120	Нийтлэг татварын бус орлого	854,778.80	409,171.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,743,103.80	2,005,993.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,491,130.60	2,420,812.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,491,130.60	2,420,812.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,384,685.80	2,420,421.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	345,294.70	478,396.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,742.70	61,229.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	887,814.20	62,172.10
2104	Хангамж, бараа материалын зардал	561,328.40	1,006,550.00
2105	Нормативт зардал	0	397.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,683.50	48,599.40
2107	Томилолт, зочны зардал	5,679.00	12,956.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,851.00	508,384.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	504,292.40	241,734.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,106,444.80	391
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	534,419.80	414,277.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,855,057.40	414,277.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,512,713.00	2,540,386.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	427,667.80	419,924.50
110	Орлогын албан татвар	218,932.40	302,812.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	218,932.40	321,305.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-18,492.80
113	Хөрөнгийн албан татвар	34,216.50	32,799.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	174,518.90	84,312.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,392.30	17,899.40
1181	Газрын төлбөр	6,830.40	10,315.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	161,296.30	56,098.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	313,695.40	114,468.20
120	Нийтлэг татварын бус орлого	313,695.40	114,468.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,771,349.80	2,005,993.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,603,178.80	1,293,944.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,603,178.80	1,293,944.40

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,451,592.50	1,291,726.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,657.50	479,799.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,132.50	60,182.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	891,748.60	62,172.10
2104	Хангамж, бараа материалын зардал	35,424.90	51,864.00
2105	Нормативт зардал	335.3	503.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,177.80	9,183.00
2107	Томилолт, зочны зардал	5,379.00	12,956.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,216.20	554,957.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,520.70	60,107.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,586.20	2,218.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	909,534.20	1,246,442.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	642,973.70	1,143,914.10
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	642,973.70	1,143,914.10
2200	Дотоод эх үүсвэрээр	642,973.70	1,143,914.10
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-642,973.70	-1,143,914.10
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-76,100.00	-36,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	76,100.00	36,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	190,460.50	66,527.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	281,253.70	471,714.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	471,714.20	538,242.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,600,248.40	11,600,248.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	282,606.20	282,606.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,882,854.60	11,882,854.60
9	Тайлант үеийн үр дүн	-6,855,057.40	-6,855,057.40
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20
19	Тайлант үеийн үр дүн	414,277.30	414,277.30
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,442,074.50	5,442,074.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,829,625.80	2,358,689.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,197,169.10	1,178,775.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,194,927.60	1,176,557.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	479,099.00	474,626.08
210101	Үндсэн цалин	268,802.10	299,883.01
210102	Нэмэгдэл	144,741.90	111,333.06
210104	Урамшуулал	10,042.00	36,778.07
210105	Гэрээт ажлын хөлс	55,513.00	26,631.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,887.40	59,579.78
210201	Тэтгэврийн даатгал	40,723.40	41,087.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,791.00	4,831.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,832.80	3,625.37
210204	Ажилгүйдлийн даатгал	958.20	974.11
210205	Эрүүл мэндийн даатгал	9,582.00	9,060.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	516,169.00	513,010.90
210301	Гэрэл, цахилгаан	40,271.20	37,810.22
210302	Түлш, халаалт	426,048.90	425,625.09
210303	Цэвэр, бохир ус	49,848.90	49,575.59
2104	Хангамж, бараа материалын зардал	40,252.60	40,248.60
210401	Бичиг хэрэг	6,595.30	6,595.30
210402	Тээвэр, шатахуун	29,010.40	29,010.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,646.90	4,642.90
2105	Нормативт зардал	503.90	503.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	503.90	503.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,998.50	13,998.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280.60	280.60
210604	Урсгал засвар	13,717.90	13,717.90
2107	Томилолт, зочны зардал	10,898.70	10,898.70
210702	Дотоод албан томилолт	10,898.70	10,898.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,434.30	13,609.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,641.90	12,672.85
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	24.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210.00	210.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30.00	30.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	915.00	570.90
210807	Газрын төлбөр	123.00	102.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,684.20	50,081.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,319.20	45,759.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,365.00	4,321.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,241.50	2,218.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,241.50	2,218.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,241.50	2,218.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,557,327.70	1,143,914.14

220001	Барилга байгууламж	921,197.00	696,393.39
221001	Их засвар	415,499.80	242,130.18
222001	Тоног төхөөрөмж	97,250.00	96,964.00
223001	Бусад хөрөнгө	123,380.90	108,426.57
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,129.00	36,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	75,129.00	36,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,829,625.80	2,332,556.51
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,245,365.50	2,228,521.34
320001	Орон нутгийн төсвөөс	1,199,364.10	1,182,519.94
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,046,001.40	1,046,001.40
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	584,260.30	104,035.17
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,405.00	4,800.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	181,483.40	99,235.17
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	397,371.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	371,238.95
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	64.00	64.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	31.00	31.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	6.00	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31.00	31.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	520,201.37	158,014.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520,201.37	158,014.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,084.91	115,169.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,922.50	5,173.23
210101	Үндсэн цалин	1,922.50	5,173.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	602.50
210201	Тэтгэврийн даатгал	0.00	602.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	454,033.44	343.78
210301	Гэрэл, цахилгаан	916.17	343.78
2104	Хангамж, бараа материалын зардал	7,135.70	11,615.39

210402	Тээвэр, шатахуун	5,815.70	11,615.39
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,778.20	2,228.68
210604	Урсгал засвар	2,778.20	2,228.68
2107	Томилолт, зочны зардал	300.00	2,058.23
210702	Дотоод албан томилолт	300.00	2,058.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,865.07	83,120.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,865.07	83,120.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050.00	10,026.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050.00	10,026.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,116.45	42,845.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,266.45	42,845.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	28,246.06	42,845.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	520,180.98	158,014.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	520,180.98	158,014.08
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	4,855.20
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,609.07	77,720.61
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	53,389.60	75,438.27

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,665,406.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 945,537.0 мянган төгрөгийн алдааг залруулан 10,000 мянган төгрөгийн албан шаардлага, 709,869.2 мянган төгрөгийн зөвлөмж өглөө. Үүнд:

- ОНХС-ийн төсөл арга хэмжээг батлахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан,
- ЗДТГ, ИТХ-ын Санхүү байдлын тайлан, Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлэн тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.1 Төлбөрийн акт

Тус байгууллагад төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага

- ✓ Төрийн албан хаагчдыг чадавхжуулах хөтөлбөрт 10.0 сая төгрөг батлан тайлант онд сумын ЗДТГ-ын албан хаагч нарыг БНХАУ-ын Урумч хотод аялах замын зардлыг давсан орлогоос тодотгол хийн ОНХС-ийн хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардалд батлан төсвийн хөрөнгөөр аялал зохион байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 60 дугаар зүйлийн 60.3.4-д “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэлт: Албан шаардлага өгөх

3.3 Зөвлөмж

3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээ байгуулсан дүнгээс 0.05 хувийн алданги төлнө гэж гэрээнд тусгасан боловч алданги дутуу тооцон суутгаагүй 8,571.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг мөрдөж ажиллах дууссан ажлуудын гэрээг дүгнэж хугацаа хэтэрсэн ажлуудад алданги тооцож хэвших

Илрүүлэлт: ОНХС-ийн төсөл арга хэмжээг батлахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4.”Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно, 29.1.Захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ” гэсэнтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахгүй байх, хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

Илрүүлэлт: ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.2.2-д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын үр өгөөж буурсан байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж дууссан болон дуусаагүй ажлуудад хяналтыг хэрэгжүүлэн ажиллах, хэрэгжилт хангагдахгүй байгаа газруудад хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах

3.2.2 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгохдоо “Хошоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6.3-д сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх хоршоо нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: 6.3.1.тухайн суманд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг байх; 6.3.2.Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;гэсэн заалтын хэрэгжилт хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Журмын хэрэгжилтийг ханган ажиллаж анхан шатны баримт бүрдүүлэлтийг бүрэн хийж, олгосон зээлүүдэд хяналт хэрэгжүүлэн ажиллах,
Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Орон нутгийн хөгжлийн сан													
	ДҮН												

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Орон нутгийн хөгжлийн сан	Сумын давсан орлогоос ОНХС-д хөтөлбөр баталж, төрийн албан хаагчдын чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд 19 төрийн албан хаагчийг Хятад Улсын Үрэмч хотод аялуулсан.	1	10,000.0			1	10,000.0					
	Гүйцэтгэсэн ажлуудыг гэрээний дагуу алданги тооцохдоо бүрэн тооцож суутгаагүй	1	8,571.0					1	8,571.0			
	ОНХС-ийн төсөл арга хэмжээг батлахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.	1	653,664.2						1	653,664.2		
	ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.2.2-д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын үр өгөөж буурсан байна.	1	0						1	0		
Хоршоо хөгжүүлэх сан	ХХС-ийн зээл олгохдоо анхан шатны баримтын иж бүрдлийг бүрдүүлээгүй	1						1				
		5	672,235.2			1	10,000.0	4	662,235.2			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Байгууллагын нэр	Аудитад хамрагдвал зохих	Хамрагдсан	Байгууллагын тоо		Аудитын санал дүгнэлтийн төрөл			
			Гүйцэтгэсэн		үүнээс			
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Зөрчилгүй	Хязгаар лалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
ИТХ	1	1		1				
ЗДТГ	1	1		1				
Хоршоо хөгжүүлэх сан	1	1		1				
Орон нутгийн хөгжлийн сан	1	1		1		-	-	-
НИЙТ	4	4	-	4	-	-	-	-